

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/020/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Хатанбаатар

Утас: 70272287 Цахим хаяг: khatanbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зууныод сум
Утас: 70272582, Факс: 70272582, Хаяг: тусгай.төв.аудит.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.24 № 01/2025
таний -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.САМБУУ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын төвөөс Баянхангай сум хүртэлх хатуу хучилттай замын ажил 15,008,101.1 мянган төгрөгөөр, 2 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын ажил 4,900,882.0 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1 дүгээр сургуулийн барилгын их засварын ажил 1,599,642.5 мянган төгрөгөөр, Шинэ сум төслийн дулаан, цэвэр усны шугамын ажил 1,695,514.9 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 144,7 хувиар буюу 2,231,305.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 119,2 хувиар буюу 452,600.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 48,4 хувиар буюу 175,558.5 мянган төгрөгөөр тасалж нийт 3 шатны орлогын төлөвлөгөөг 132,6 хувиар буюу 2,508,347.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Үүнээс нутагт төвлөрүүлэх газрын төлбөрийг 28,026.2

мянган төгрөгөөр буюу 95,7 хувиар, ус ашигласны төлбөр 219,861.2 мянган төгрөгөөр буюу 86,3 хувиар, улсын төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 54,636.3 мянган төгрөгөөр буюу 65,2 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварыг 133,514.7 мянган төгрөгөөр буюу 12,6 хувиар орлого тасалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Заамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 04 дүгээр сарын 21-ний 09 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 18 зорилт 67 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 93,26 хувьтай буюу "Үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,763,755.05	6,822,402.82
1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,995,860.95	4,800,353.53
1.1.3 АВЛАГА	366,402.54	1,561,264.18
1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	401,491.56	460,785.12
1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,804,042.73	10,675,718.03
1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,804,042.73	10,675,718.03
1.2.2.02 Биет хөрөнгө	8,039,013.08	7,845,139.43
1.2.2.03 Биет бус хөрөнгө	765,029.65	2,830,578.60
1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	12,567,797.77	17,498,120.86
2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	249,251.06	345,227.54
2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	249,251.06	345,227.54
2.1.1.03 Өглөг	249,251.06	345,227.54
2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,318,546.71	17,152,893.31
2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	12,318,546.71	17,152,893.31
2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	2,257,283.20	2,257,283.20
2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	9,652,104.13	14,486,450.73
2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	409,159.38	409,159.38
2 ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	12,567,797.77	17,498,120.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,904,141.43	11,788,110.33
1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	4,687,894.28	6,620,806.78
1.1.1.03.1 Орлогын албан татвар	4,244,172.74	5,720,055.28
1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	4,244,172.74	5,720,055.28
1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	113,467.55	254,576.93
1.1.1.03.8 Бусад татвар төлбөр хураамж	330,253.99	646,174.57
1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	531,742.92	5,167,303.55
1.1.1.04.3 Тусламжийн орлого	5,000.00	127,266.00
1.1.1.05 ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,684,504.23	-
1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,995,909.13	4,638,749.54
1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	4,490,538.31	4,357,093.73
1.1.2.01.1 БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,180,074.44	3,547,359.93
1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	854,483.34	972,272.02
1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,241.38	120,226.92
1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,083,545.97	1,291,365.71
1.1.2.01.1.04 Хангамж бараа материалын зардал	104,326.28	141,952.03
1.1.2.01.1.05 Нормативд зардал	659.90	-
1.1.2.01.1.06 Эд хогшил урсгал засварын зардал	53,111.00	56,696.78
1.1.2.01.1.07 Томилотт зочны зардал	14,161.50	15,280.00
1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,905.22	96,490.19
1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	951,639.85	853,076.27
1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,310,463.87	809,733.80
1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	505,370.82	281,655.81
1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,908,232.29	7,149,360.79

1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	295,963.26	2,357,645.18
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(295,963.26)	(2,357,645.18)
1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,612,269.03	4,791,715.62

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,706,277.68	9,706,277.68
1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,706,277.68	9,706,277.68
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	2,612,269.03	2,612,269.03
1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,318,546.71	12,318,546.71
1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,318,546.71	12,318,546.71
1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	42,630.98	42,630.98
1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,361,177.69	12,361,177.69
1.7 Тайлант үеийн үр дүн	4,791,715.62	4,791,715.62
1 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	17,152,893.31	17,152,893.31

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,699,068.97	9,565,072.09
1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	4,687,894.28	6,620,806.78
1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	4,244,172.74	5,720,055.28
1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	113,467.55	254,576.93
1.1.1.1.03.8 Бусад татвар төлбөр хураамж	330,253.99	646,174.57
1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр хураамж	22,181.80	26,296.00
1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	308,072.19	619,878.57
1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	326,670.47	2,944,265.31
1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	321,670.47	875,922.21
1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	5,000.00	127,266.00
1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,941,077.10
1.1.1.1.05 ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,684,504.23	-
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,023,599.27	3,859,666.02
1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	4,023,599.27	3,859,666.02
1.1.1.2.01.1 БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,712,254.04	3,052,735.18
1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	863,640.14	971,906.99
1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,241.38	120,226.92
1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,234,701.13	1,288,139.39
1.1.1.2.01.1.04 Хангамж бараа материалын зардал	114,653.40	113,338.37
1.1.1.2.01.1.05 Нормативд зардал	113,462.25	139,304.93
1.1.1.2.01.1.06 Эд хогшил урсгал засварын зардал	68,164.25	125,089.78
1.1.1.2.01.1.07 Томилолт зочны зардал	4,161.50	15,280.00
1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,075.62	103,743.10
1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	183,154.37	175,705.70
1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,311,345.23	806,930.84
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,675,469.71	5,705,406.07

1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,024,609.55	3,868,315.41
1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,024,609.55	3,868,315.41
1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	2,024,609.55	3,868,315.41
1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,024,609.55)	(3,868,315.41)
1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50.00	30,150.00
1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	2,448.09
1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(50.00)	(32,598.09)
1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,650,810.15	1,804,492.58
1.2 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,345,050.80	2,995,860.95
1 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,995,860.95	4,800,353.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,079,476.50	13,291,602.33	(1,212,125.83)
3.1.01.1.1 Татварын орлого	4,894,800.50	6,620,806.78	(1,726,006.28)
3.1.01.1.2 Татварын бус орлого	7,184,676.00	6,670,795.54	513,880.46
3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,673,696.20	11,569,146.26	(1,895,450.06)
3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	3,945,283.90	7,670,680.86	(3,725,396.96)
3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,091,784.60	2,806,506.73	285,277.87
3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	912,690.10	878,000.80	34,689.30
3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,242.10	108,541.96	5,700.14
3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,340,895.60	1,288,139.39	52,756.21
3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	139,074.10	109,655.60	29,418.50
3.1.01.2.1.1.5 Нормативд зардал	2,380.00	2,374.40	5.60
3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	136,100.00	125,089.78	11,010.22
3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	22,656.00	15,280.00	7,376.00
3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184,592.70	103,719.10	80,873.60
3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	239,154.00	175,705.70	63,448.30
3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	853,499.30	4,864,174.12	(4,010,674.82)
3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	726,359.30	4,787,652.58	(4,061,293.28)
3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	127,140.00	76,521.54	50,618.46
3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,646,412.30	3,868,315.41	1,778,096.89
3.1.01.2.2.1 Барилга байгууламж	3,084,623.10	1,877,116.11	1,207,507.00
3.1.01.2.2.2 Их засвар	2,209,583.70	1,738,793.99	470,789.71
3.1.01.2.2.3 Тоног төхөөрөмж	196,015.00	189,314.81	6,700.19
3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	156,190.50	63,090.50	93,100.00
3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	82,000.00	30,150.00	51,850.00
3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	82,000.00	30,150.00	51,850.00
3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,405,780.30	1,722,456.06	683,324.24

3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,405,780.30)	(1,722,456.06)	(683,324.24)
3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,405,780.30)	(1,722,456.06)	(683,324.24)
4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,711,559.07	(2,711,559.07)
5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,431,567.04	(4,431,567.04)
6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	70.00	66.00	4.00
6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-
6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО	34.00	32.00	2.00
6.2.01 Удирдах ажилтан	9.00	9.00	-
6.2.02 Гүйцэтгэх ажилтан	15.00	13.00	2.00
6.2.03 Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-
6.2.04 Гэрээт ажилтан	3.00	3.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	489,277.20	117,266.00
1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	489,277.20	117,266.00
1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	489,277.20	117,266.00
1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	489,277.20	117,266.00
1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	489,277.20	117,266.00
1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	489,277.20	106,649.07
1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,101.35
1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,515.59
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	486,662.50	113,323.92
1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	177,437.90	113,323.92
1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	144,853.10	109,273.92
1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,763.20	93,906.18
1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,976.50	11,684.96
1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	7,586.30	3,682.77
1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	2,500.00	-
1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	2,199.50	-
1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,103.60	-
1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	31,723.90	-
1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,614.70	4,050.00
1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	2,614.70	4,050.00
1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,614.70	3,942.09
1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,614.70)	(3,942.09)
1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,614.70)	(3,942.09)

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа гараагүй.

Нийт алдаа, зөрчлөөс 436,038.4 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус, урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 85,191.1 мянган төгрөгөөс бага буюу материаллаг алдаа илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 436,038.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 436,038.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага бичээгүй

5.3 Зөвлөмж

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд орон нутагт төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогыг 247,887.4 мянган төгрөгөөр, улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогыг 188,151.0 мянган төгрөгөөр нийт 436,038.4 мянган төгрөгөөр орлого тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг дарга	1	1			1			
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Засаг даргын тамгын газар	1	1			1			
4	Заамарын хөгжил ОНӨТҮГ	1		1					

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn